



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 1/02

Эмзэлтөлгөй

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын гамшигаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 4.1.23, 4.1.17, 32 дугаар зүйлийн 32.1.9, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хөндлөн булаг 3 дугаар багийн нутаг Мандалын Хонхорын бууц, Шавагтай Хөх Эрэг зэрэг газруудад гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний халдвaryг таслан зогсоох, голомтыг устгах, халдварт тархааас урьдчилан сэргийлэх зорилгоор шүлхий өвчний сүүлийн шинж тэмдэг илэрсэн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн тооцож “Хорио цээрийн дэглэм”-ийг 28 хоногийн хугацаатай тогтоож, халдвaryн голомтод байгаа мал сүрэгт үзлэг тандалт, халдвартгүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласнаар өвчний дэгдэлт буурч дахин голомт нэмэгдээгүй тул 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний үед мөрдөгдөж байгаа хязгаарлалтын дэглэмийг баримтлан, хяналтын постонд гарч байгаа албан хаагчдийг удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Ганзориг)-д, шүлхий өвчний хариу арга хэмжээ, хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэх, халдвaryн шинэ голомт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг “Буурал эг хайрхан” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Т.Уранчимэг), багийн Засаг дарга (А.Лхагвадорж)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхам-Осор)-т үүрэг болгосугай

ДАРГА

Д.МОНХЖАРГАЛ